

Газар эзэмших эрхийг
баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 29 дүгээр зүйлийн 29.1, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэд, хүүхэд залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заал барих зориулалтаар тус дүүргийн 19 дүгээр хороо, Дээд салхитын аманд 800 м2 газрыг 15 жилийн хугацаатайгаар Засаг даргын Тамгын газрын нэр дээр эзэмших эрхийг баталгаажуулсугай.

2. Газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газрын албанд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ